



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХИ.34. "ХЭЛЭЛЦСЭН нь: Дахин төлөвлөлтийн тухай

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, конторын барилга (хуучнаар Татварын ерөнхий газрын байр) нь цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй, хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахгүй, галд тэсвэртэй, цахилгаан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байх заалтыг хангахгүй, ус, дулаан, цахилгаан хангамжийн аюулгүй байдал, тасралтгүй, найдвартай ажиллагаа доголдох нөхцөл бүрдсэн гэж Нийслэлийн Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн 2021 оны 02-07-091/855 дугаар актаар тогтоогдсон тул дахин төлөвлөлтөд хамруулах тухай хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах конторын барилга (Эрдэнэс таван толгой ХХК-ийн түрээсээр эзэмшдэг байр)-ыг дахин төлөвлөлтөд оруулж, шинээр конторын зориулалттай барилга барих нь зүйтэй гэж үзэв.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132002305